



# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТ - 2025 ОН

НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН НЭГДСЭН СУДАЛГАА

**Гүйцэтгэсэн:**

А.Авир, хэлтсийн дарга  
Л.Мөнхзаяа, ахлах референт  
Т.Энхзаяа, ахлах мэргэжилтэн  
Ж.Лхагвамядаг, мэргэжилтэн  
Б.Арьяаманал, мэргэжилтэн

Компанийн засаглал, комплайнсын хэлтэс

2026 он

# “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-Д БҮРТГЭЛТЭЙ ҮНЭТ ЦААС ГАРГАГЧДЫН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТ - 2025 ОН

## 1. ҮЙЛ ЯВДЛЫН ӨРНӨЛ

### 2006 он

Монгол Улсын Их хурлаас “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийг баталж, компанийн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, боловсронгуй болгох бүрэн эрхийг тус Хороонд олгов.

### 2007 он

“Монгол компанийн засаглалын кодекс”-ийг Хороо анх удаа батлав.

### 2014 он

“Компанийн засаглалын кодекс”-д нэмэлт, өөрчлөлтийг оруулав.

### 2022.03.23

Хорооны 145 дугаар тогтоолоор “Компанийн засаглалын кодекс”-ийн шинэчилсэн найруулга батлагдлаа. Шинэчилсэн кодексийн хавсралтаар олон улсад түгээмэл ашиглагддаг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмаар үнэлгээний аргачлал бүхий тайлангийн маягт болон компанийн дотооддоо баталж, мөрдөх бодлогын баримт бичиг, дүрэм, журмын зааврын үлгэрчилсэн загваруудыг батлав.

### 2022.04.15

Кодекс “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэл”-д бүртгэгдэж, эрх зүйн мэдээллийн [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn) нэгдсэн системд байршсанаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн ба нээлттэй хувьцаат компани (ХК), даатгагч, итгэлцлийн үйлчилгээ эрхлэгч банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болон хөрөнгө оруулалтын менежментийн компани (ХОМК) дагаж мөрдөх үүргийг хүлээв.

### 2022.06.22

Хорооны даргын 2022 оны 336 дугаар тушаалаар “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлын удирдамж”-ийг баталж, компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх нэгдсэн зохион байгуулалт, зах зээлд оролцогч талуудын баримтлах зарчим, чиг үүргийг тодорхойлов.

### 2022.11.03

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 1 болон 2 дугаар ангилалд бүртгэлтэй нийт 66 ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагыг оролцуулан кодексийн хэрэгжилтийн үнэлгээг хэрхэн тайлагнах сэдвээр нийтдээ 6 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав.

### **2022.12.30**

Хорооны зохицуулалтын 3 салбарын нийт 116 зохицуулалттай этгээд (даатгагч, ББСБ, ХОМК)-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг үнэлэн тайлангийн хариугаар заавар зөвлөмж, эсхүл хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг нь тооцон салбар тус бүрийн зэрэглэлийг тогтоож, нийтэд мэдээлэв. Үнэлгээг хянан баталгаажуулахад, 2022 оны наймдугаар сарын байдлаар кодексийн хэрэгжилтийн анхны буюу нөхцөл байдлын үнэлгээ **55.3** хувийн гүйцэтгэлтэй байсан бол Хорооноос үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, мөн оны 12 дугаар сард биелэлтийг нь тооцсон давтан үнэлгээгээр зохицуулалттай 3 салбарын кодексийн хэрэгжилт дунджаар **16.4** хувиар өсөв.

### **2023.01.02**

“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын кодексийн хэрэгжилтийг үнэлэх ажлыг эхлүүлэв.

### **2023.03.01**

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 1, 2 дугаар ангиллын 68 ХК, 3 дугаар ангилалд бүртгэлтэй 40 ХК, нийт 108 ХК-ийн кодексийн хэрэгжилт **46.6** хувьтай гарсан бөгөөд үнэлгээ тус бүрийг хянан баталгаажуулан тайлангийн хариугаар хугацаатай үүрэг, даалгавар өгөгдөв.

### **2023.06.30**

Кодексийн анхдагч үнэлгээний хариугаар Хороонд ирүүлсэн нийт 47 үнэт цаас гаргагчийн тайланг давтан үнэлж, ахиц дэвшлийг тогтооход кодексийн хэрэгжилт дунджаар **15.9** хувиар өсжээ. Ингэснээр компанийн засаглалын чанар буюу кодексийн хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд суурилсан зэрэглэл тогтоож эхлэв. Кодексийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж, нэгдсэн тайлан гаргаж, зэрэглэл тогтоосноор компанийн засаглалын өнөөгийн нөхцөл байдал, эрсдэл, чиг хандлагыг тодорхойлон зохицуулалтын орчныг оновчтой болгох, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдад шийдвэр гаргахад нь шаардлагатай чанарын үзүүлэлтүүд бий болов.

### **2023.12.28**

Нийт 124 тусгай зөвшөөрөлтэй компани (Даатгагч, ББСБ, ХОМК)-ийн кодексийн хэрэгжилтийг хянан баталгаажуулахад 2023 оны эцсийн байдлаар дундаж үнэлгээ 2022 оныхоос **30** гаруй хувиар дээшилсэн дүн гарлаа. Хөрөнгийн биржид бүртгэлтэй 104 ХК-ийн кодексийн хэрэгжилтийн үнэлгээ **56.1** хувьд хүрч, оны эцсээр **9.5** хувийн ахиц дэвшлийг үзүүлэв.

### **2024.02.08**

Хорооны даргын 2024 оны 52 дугаар тушаалаар “Комплайнсын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал” батлагдав. Энэхүү аргачлалыг таниулж, нэвтрүүлэх зорилгоор даатгагч, ХОМК, ББСБ, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч (ВХҮҮ)-ийн эрх бүхий албан тушаалтнуудад “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт, комплайнсын эрсдэлийг үнэлэх нь” сэдвээр нийтдээ 3 удаагийн сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

### **2024.06.28**

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 108 ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ 2024 оны эхний хагас жилийн байдлаар **56.4** хувьд хүрсэн ба үнэлгээний тайлангийн хариугаар компани тус бүрд зөвлөмж, чиглэл, хугацаатай үүрэг даалгавар өгч, биелэлтийг тооцов. 2024 оны эхний хагас жилийн байдлаар тайлангаа ирүүлсэн **37** компанийн давтан үнэлгээ дунджаар **64.8** хувьд хүрэв.

### **2025.01.20**

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 111 ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ 2024 оны эцсийн байдлаар **64.2** хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад **8.1** хувиар өсөв. 2024 оны жилийн эцсийн байдлаар тайлангаа ирүүлсэн 44 компанийн давтан үнэлгээг хянан баталгаажуулахад, кодексийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ **72.5** хувьд хүрчээ.

### **2025.06.30**

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 113 ХК-ийн тайланг 2025 оны эхний хагас жилийн байдлаар хянан баталгаажуулахад, кодексийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ **62.1** хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад **5.7** хувиар өсөв.

### **2025.12.31**

Хөрөнгийн биржид бүртгэлтэй 112 ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ 2025 оны эцсийн байдлаар **61.8** хувьд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад **2.4** хувиар буурав. 2025 оны жилийн эцсийн байдлаар тайлангаа ирүүлсэн 40 компанийн давтан үнэлгээг хянан баталгаажуулахад, кодексийн хэрэгжилтийн жилийн дундаж үнэлгээ **78.3** хувьд хүрч, өмнөх оны мөн үеийнхээс **5.8** хувиар өсөлтийг үзүүлэв.

## **2. СУДАЛГААНЫ ТАЛААР**

Компанийн засаглалыг нэвтрүүлэх нь бизнесийн үйл ажиллагааны урт хугацааны өгөөжийг хангах төдийгүй хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн хүлээлтэд суурилсан шударга, нээлттэй зах зээлийн орчин бүрдэхэд эергээр нөлөөлдөг тул нийгэмд ач холбогдолтой энэ сэдвийг онцгойлон анхаарч, тогтмол хөгжүүлэх шаардлагатай.

Олон улсын практикийн дагуу компанийн засаглалын чанар, кодексийн хэрэгжилтийг үнэлэхдээ эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн зэрэглэл тогтоох аргыг ашиглав.

Компанийн засаглалын зэрэглэл нь тухайн компанийн үйл ажиллагаанд эрсдэлийн дүн шинжилгээ хийх мэдээлэл болж өгснөөр хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрсдэлгүй шийдвэр гаргалтад эергээр нөлөөлнө.

## **3. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ**

- “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлж нэгдсэн тайлан боловсруулах;
- компанийн засаглалын хандлага, учирч болох эрсдэлийг тодорхойлох;
- хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч эрсдэлийн үнэлгээ хийж, шийдвэр гаргах засаглалын үзүүлэлтийг бий болгох;

- үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн ангилал бүрээр засаглалаар тэргүүлэгчдийг тодруулах, компанийн засаглалын зэрэглэл тогтоох;
- нээлттэй хувьцаат компаниудад өөрийн засаглалыг харьцуулах, сайжруулахад чиг баримжаа болох компанийн засаглалын жишгийг тодорхойлох;
- хууль тогтоомж болон хувьцаат компанийн баталсан дотооддоо дагаж мөрдөх дүрэм, журмын эрх зүйн орчныг оновчтой болгож, сайжруулах;
- хугацааны цуваа хэлбэрээр статистик мэдээллийг үүсгэх.

#### 4. АРГАЧЛАЛ

Судалгаа нь “Компанийн засаглалын кодекс”-ийн 36 зүйлийн хэрэгжилтийн асуумжаар “Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй 112 ХК-ийн суурь, 40 ХК-ийн давтан үнэлгээ болон Хорооноос хэрэгжүүлсэн судалгааны үр дүнд суурилсан.

##### 4.1. СУДАЛГААНЫ ГОЛЛОХ СЭДЭВ:

**а. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын үйл ажиллагаа, бүтэц, бүрэлдэхүүн.**

**б. дотоод эрх зүйн зохицуулалтын ил тод байдал /цахим хуудасны шинэчлэл/:**

- бодлогын баримт бичиг;
- ёс зүйн дүрэм;
- компанийн дүрэм, дотоод үйл ажиллагааны журам;
- мэдээллийн ил тод байдал, тайлагнал, комплайнсын хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны журам, заавар;
- компанийн эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр.

**в. хамгийн сайн болон муу хэрэгжсэн засаглалын үзүүлэлтүүд.**

##### 4.2. СУДАЛГААНД ХАМРАГДСАН:

**“Монголын хөрөнгийн бирж” ХК-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниуд:**

а. Компанийн засаглал, комплайнсын хэлтсээс нийт 112 хувьцаат компанид суурь үнэлгээг хийж, тайлангийн хариугаар хугацаатай үүрэг бүхий албан тоот хүргүүлснээр нийт 40 компанийн давтан зайны үнэлгээг кодексийн хавсралт болох асуулгын маягтын дагуу гүйцэтгэж, оноогоор үнэлэв.


б. Компаниудын ирүүлсэн зайны үнэлгээг хавсаргасан нотлох баримтад үндэслэн үнэлгээний хяналтын оноо болон хувиар нэгдсэн дүнг тооцов.

в. Үнэлгээний нэгдсэн дүнг үндэслэн компани тус бүрд тухайлсан зөвлөмж, чиглэл хүргүүлэн тэдгээрийн биелэлтээр зайны үнэлгээний ахиц дэвшлийг тодорхойлов.

Компанийн үнэлгээний нэгдсэн дүн нь тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэл хийхтэй холбоотойгоор Хорооноос холбогдох шийдвэр гаргах, компанийн засаглалын тухайн үеийн нөхцөл байдлыг тодорхойлох болон эрх зүйн орчныг боловсронгуй, оновчтой болгох чиглэлд дүн шинжилгээ хийх, мөн компанийн засаглалын зэрэглэлийн нэгдсэн судалгааг гарган нийтлэх, мэдээллийн зорилгоор ашиглагдана.

## 5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


ДҮРСЛЭЛ 1. МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-Д БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:



### Шигтгээ 1:

Кодексийн тайлбар хэсэгт заасан ТУЗ, түүний дэргэдэх хороод, дарга, гишүүдийн ажлын тайлан, гүйцэтгэлийн үнэлгээ, ТУЗ-ийн дарга, гишүүдийн хараат бус байдал, хүйсийн харьцаа, хороодын дарга нарт тавигддаг зөвлөмжүүдийг заавал дагаж мөрдөх шаардлага болгон кодексийн үнэлгээний аргачлалд нийт 7 тохируулгыг нэмж, тус бүр нэг оноогоор үнэлж, комплайнсын хяналтыг хэрэгжүүлж эхэлснээр нийт 112 компанийн 2025 оны жилийн эцсийн дундаж үнэлгээ өмнөх үеийнхээс 2.4 хувиар буурав

ДҮРСЛЭЛ 2. ХУГАЦААТАЙ ЧИГЛЭЛ, ҮҮРГЭЭР “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ:




**Шигтгээ 2:**

2025 оны жилийн эцсийн байдлаар тайлангаа шинэчлэн ирүүлсэн 40 ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ өмнөх оны мөн үеийнхээс дунджаар 5.8 хувиар өсөлтийг үзүүлэв

**Шигтгээ 3:**

2025 оны жилийн эцсийн байдлаар тайлангаа шинэчлэн ирүүлсэн 40 ХК-ийн Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй компаниудын үнэлгээ өмнөх оны мөн үеийнхээс дунджаар 7.7, II ангилал 3.6, III ангиллын үзүүлэлт 6.1 хувиар тус тус өсжээ

**ДҮРСЛЭЛ 3. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН БИРЖИЙН БҮРТГЭЛИЙН АНГИЛЛЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ (“МХБ ХК”-д бүртгэлтэй 112 ХК):**




**Шигтгээ 4:**

Хөрөнгийн биржийн нэгдүгээр ангиллын компаниуд компанийн соёлыг төлөвшүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрхийг тэгш хангах, эрсдэлийн удирдлагыг зохистойгоор зохион байгуулах, компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрхийг тэгш хангах зэрэг ажлууд хангалттай хэрэгждэг гэж үнэлэгдэв

**Шигтгээ 5:**

ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны үр дүн хамгийн сул үнэлгээтэй гарсан нь зарим компаниудын ТУЗ жилийн ажлын гүйцэтгэлээ үнэлдэггүй, хороод тайлан гаргадаггүйгээс дундаж үнэлгээ буурахад нөлөөлөв


ДҮРСЛЭЛ 4. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БҮРТГЭЛИЙН АНГИЛЛЫН ХАРИЛЦАН ХАМААРАЛ (Давтан тайлан ирүүлсэн 40 ХК):




ДҮРСЛЭЛ 5. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТ ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ (Давтан тайлан ирүүлсэн 40 ХК):




ДҮРСЛЭЛ 6. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ (100.0 ТЭРБУМ ТӨГРӨГӨӨС ДЭЭШ)



**ДҮРСЛЭЛ 7. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ (10.0-100.0 ТЭРБУМ ТӨГРӨГ ХҮРТЭЛ)**




**ДҮРСЛЭЛ 8. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТ БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХАРИЛЦАН ХАМААРАЛ (10.0 ТЭРБУМ ТӨГРӨГ ХҮРТЭЛ)**



**Шигтгээ 6:**

“Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн болон зах зээлийн үнэлгээ, бүртгэлийн ангиллын хооронд харилцан хамаарал ажиглагдлаа

**ДҮРСЛЭЛ 9. МХБ ХК-Д БҮРТГЭЛТЭЙ НИЙТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
“КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛД ХИЙГДСЭН НЭМЭЛТ  
ТОХИРУУЛГА БУЮУ ШААРДЛАГА:**




**ДҮРСЛЭЛ 10. ЦАХИМ ХУУДСАНДАА ИЛ БОЛГОХ ШААРДЛАГАТАЙ МЭДЭЭЛЭЛ:**



## 6. “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН БҮРТГЭЛИЙН НЭГДҮГЭЭР АНГИЛАЛ


ДҮРСЛЭЛ 11. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:



Шигтгээ 7:

Хөрөнгийн нэгдүгээр бүртгэлтэй 18 гаргагчийн хэрэгжилтийн үнэлгээ өмнөх үетэй харьцуулахад 7.7 хувиар өсөв


ДҮРСЛЭЛ 12. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ:



Шигтгээ 8:

ТУЗ нь бизнесийн ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх, эрсдэлийн удирдлага, комплайнсын хяналтыг зохистой, хараат бус байдлаар хэрэгжүүлэх, оролцогч талуудтай харилцах, мэдээлэл солилцох зэрэг ажлуудыг хангалттай сайн зохион байгуулсан гэж үнэлэгдсэн бол ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааг ач холбогдлоор нь зохистой байдлаар төлөвлөх, жилийн ажлын гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх зэрэг ажлууд чамлалттай байв

ДҮРСЛЭЛ 13. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН:



Шигтгээ 9:

ТУЗ-ийн бүрэлдэхүүн: **9-12**, тэдгээрийн **35.4** хувь нь хараат бус бөгөөд 2024 онд энэ хувь **36.6** байв

Шигтгээ 10:

ТУЗ-ийн бүрэлдэхүүний **33.3** хувь нь эмэгтэйчүүд эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс **11** хувиар өсжээ


ДҮРСЛЭЛ 14. ТУЗ-ИЙН ХУРАЛ:

Он	2023	2024	2025
ТУЗ-ийн хурлын дундаж тоо	21	18	9
Хурлын дундаж ирц	94%	95%	89%
Хэлэлцсэн асуудлын дундаж тоо	51	49	58


Шигтгээ 11:

2025 онд хуралдсан ТУЗ-ийн хурлын тоо 2 дахин, хурлын ирц **6.0** хувиар буурсан бол хурлаар хэлэлцсэн асуудлын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад, **18.4** хувиар өсжээ


ДҮРСЛЭЛ 15. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):




ДҮРСЛЭЛ 16. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:




ДҮРСЛЭЛ 17. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ:



ДҮРСЛЭЛ 18. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:



ДҮРСЛЭЛ 19. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ХУРАЛ БОЛОН ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТОО (Дунджаар):



*Шигтгээ 12:*

*ТУЗ-ийн дэргэдэх хороод дунджаар тус бүр 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг*

ДҮРСЛЭЛ 20. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:



Шигтгээ 13:


2025 оны байдлаар **89.0** хувь нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулжээ

Шигтгээ 14:


Тайлант хугацаанд **78.0** хувь нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон байна

ДҮРСЛЭЛ 21. КОДЕКСИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:




Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



## 7. “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН БҮРТГЭЛИЙН ХОЁРДУГААР АНГИЛАЛ

ДҮРСЛЭЛ 22. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:



Шигтгээ 15:

Хөрөнгийн хоёрдугаар бүртгэлтэй компанийн хэрэгжилтийн үнэлгээ өмнөх үетэй харьцуулахад **3.6** хувиар өсөв

биржийн ангилал **16** кодексийн давтан оны мөн

ДҮРСЛЭЛ 23. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ:



Шигтгээ 16:

ТУЗ нь компанийн бизнесийн ёс зүйн хэм хэмжээг тогтоон мөрдүүлэх, хувьцаа эзэмшигчдийн эрхийг тэгш хангах зэрэг нь харьцангуй сайн гэж үзэхээр бол ТУЗ-ийн эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллыг ил тод байлгах, ТУЗ-ийн жилийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэлийн үр дүнгээ үнэлэх зэрэг ажлууд хангалтгүй хийгдсэн байв

ДҮРСЛЭЛ 24. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН:



**3-4** хараат  
бус гишүүн  
**5-6** энгийн  
гишүүн


Шигтгээ 17:

ТУЗ **9** гишүүний бүрэлдэхүүнтэйгээс  
**36.7** хувь нь хараат бус гишүүд


Шигтгээ 18:

ТУЗ-ийн бүрэлдэхүүний **26.0** хувь  
нь эмэгтэй байв

ДҮРСЛЭЛ 25. ТУЗ-ИЙН ХУРАЛ:




ДҮРСЛЭЛ 26. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРЦЛАГА (Жилээр):



ДҮРСЛЭЛ 27. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



ДҮРСЛЭЛ 28. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:




ДҮРСЛЭЛ 29. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ХУРАЛ БОЛОН ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТОО (Дунджаар):



Шигтгээ 19:

ТУЗ-ийн дэргэдэх хороод дунджаар тус бүр 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг

ДҮРСЛЭЛ 30. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:



- Мэдээлэл бүрэн байршуулсан
- Мэдээлэл дутуу байршуулсан
- Шинэчлэлт хийж байгаа

Шигтгээ 20:


2025 оны байдлаар **66.0** хувь нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулжээ

Шигтгээ 21:


Тайлант хугацаанд **71.0** хувь нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгосон байна

ДҮРСЛЭЛ 31. КОДЕКСИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:




Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



## 8. “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН БҮРТГЭЛИЙН ГУРАВДУГААР АНГИЛАЛ

ДҮРСЛЭЛ 32. КОДЕКСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН АХИЦ ДЭВШИЛ:



**Шигтгээ 22:**  
Хөрөнгийн гуравдугаар бүртгэлтэй 6 компанийн кодексийн хэрэгжилтийн давтан үнэлгээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад **6.1** хувиар өсөв

ДҮРСЛЭЛ 33. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН 9 ЗАРЧИМ ТУС БҮРИЙН ХЭРЭГЖИЛТ:



**Шигтгээ 23:**

ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг тэгш хангах, ТУЗ-ийн дэргэдэх хороодоор дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зэрэг нь харьцангуй сайн гэж үнэлэгдсэн бол эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллыг ил тод байлгах, компанийн санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг бүрэн хангах, компанийн бусад оролцогч талуудтай харилцах, мэдээлэл солилцох зэрэг ажлын үнэлгээ хангалтгүй

ДҮРСЛЭЛ 34. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН:



**3-4** хараат  
бус гишүүн  
**5-6** энгийн  
гишүүн


Шигтгээ 24:

ТУЗ нь **9** гишүүнтэйгээс **33.3** хувь нь хараат бус гишүүд байна


Шигтгээ 25:

ТУЗ-ийн бүрэлдэхүүний **37.0** хувь нь эмэгтэй байгаагаас хүйсийн харьцаа зохистой байв

ДҮРСЛЭЛ 35. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:




ДҮРСЛЭЛ 36. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНААР АЖИЛЛАСАН АЖЛЫН ТУРШЛАГА (Жилээр):




ДҮРСЛЭЛ 37. ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:



ДҮРСЛЭЛ 38. ТУЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙН НАСЖИЛТ БА ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ:




ДҮРСЛЭЛ 39. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ХУРАЛ БОЛОН ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТОО (Дунджаар):



Шигтгээ 26:

ТУЗ-ийн дэргэдэх хороод дунджаар тус бүр 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг

ДҮРСЛЭЛ 40. ЦАХИМ ХУУДСАНД БАЙРШУУЛСАН ДОТООД ДҮРЭМ, ЖУРМЫН НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙДЛЫН МЭДЭЭЛЭЛ:



Шигтгээ 27:


2025 оны байдлаар **39.0** хувь нь компанийн дүрмээ өөрийн цахим хуудсандаа байршуулжээ

Шигтгээ 28:


Тайлант хугацаанд **40.0** хувь нь дотоод дүрэм, журмаа нээлттэй болгов

ДҮРСЛЭЛ 41. КОДЕКСИЙН САЙН БОЛОН СУЛ ХЭРЭГЖСЭН КОДЕКСИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

Хамгийн сайн хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



Хамгийн сул хэрэгжсэн компанийн засаглалын үзүүлэлтүүд:



**9. “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭГЭЭР ТООЦСОН ЗАСАГЛАЛЫН ЗЭРЭГЛЭЛ (2025 оны сүүлийн хагас жилээр давтан үнэлгээгээ ирүүлсэн компанийн нэрийг **bold**, 1 дүгээр ангиллын компанийг **ногоон**, 2 дугаар ангиллын компанийг **цэнхэр**, 3 дугаар ангиллын компанийг **шар өнгөөр** тус тус тодруулав)**

Д/д	Компанийн нэрс	Үнэлгээ
1	"СҮҮ" ХК	100.0%
2	"ГОВЬ" ХК	98.6%
3	"БОДЬ ДААТГАЛ" ХК	98.6%
4	"ТЕХНИК ИМПОРТ" ХК	98.6%
5	"ХААН БАНК" ХК	98.6%
6	"МОНГОЛ ДААТГАЛ" ХК	97.2%
7	"ЛЭНДМН ББСБ" ХК	97.2%
8	"ТӨРИЙН БАНК" ХК	95.8%
9	"ГЕРМЕС ЦЕНТР" ХК	94.4%
10	"СЭНДЛИ ББСБ" ХК	94.4%
11	"АПУ" ХК	93.1%
12	"ИНВЕСКОР ББСБ" ХК	93.1%
13	"МОНЛОЖИСТИКС ХОЛДИНГ" ХК	93.1%
14	"ТЭНГЭР ДААТГАЛ" ХК	93.1%
15	"ХАСБАНК" ХК	93.1%
16	"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ" ХК	91.7%
17	"ПРЕМИУМ НЭКСУС" ХК	91.7%
18	"УЛААНБААТАР-БҮК" ХК	91.7%
19	"МАНДАЛ ДААТГАЛ" ХК	90.3%
20	"ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК" ХК	88.9%
21	"ИННОВЭЙШН ИНВЕСТМЕНТ" ХК	87.5%
22	"МИК ХОЛДИНГ" ХК	87.5%
23	"МОНОС ХҮНС" ХК	87.5%
24	"ТҮМЭН ШУВУУТ" ХК	87.5%
25	"АРД ДААТГАЛ" ХК	86.1%
26	"АРД КРЕДИТ ББСБ" ХК	86.1%

Д/д	Компанийн нэрс	Үнэлгээ
57	"ЖИДАКС" ХК	58.3%
58	"ХАСУ-МАНДАЛ" ХК	58.3%
59	"ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА" ХК	58.3%
60	"ТЭНГЭРЛИГ МЕДИА ГРУПП" ХК	58.3%
61	"ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ" ХК	56.9%
62	"ӨНДӨРХААН" ХК	56.9%
63	"ГРАНД СИСТЕМС" ХК	52.8%
64	"НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ" ХК	52.8%
65	"ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП" ХК	52.8%
66	"ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ" ХК	50.0%
67	"ДАРХАН ХҮНС" ХК	50.0%
68	"КРИПТО ҮНДЭСТЭН" ХК	50.0%
69	"ЕВРАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ ҮЦК" ХК	48.6%
70	"МАТЕРИАЛИМПЭКС" ХК	48.6%
71	"МОНГОЛ АЛТ" ХК	48.6%
72	"ЭМ ЭН ДИ" ХК	45.8%
73	"БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ ҮЦК" ХК	44.4%
74	"АДУУНЧУЛУУН" ХК	43.1%
75	"РЕМИКОН" ХК	40.3%
76	"СОР" ХК	40.3%
77	"ХОРИН ХОЁРДУГААР БААЗ" ХК	40.3%
78	"ГАН ХИЙЦ" ХК	37.5%
79	"АЛТАЙН ЗАМ" ХК	34.7%
80	"МОНГЕО" ХК	34.7%
81	"ТЭЭВЭР ДАРХАН" ХК	34.7%
82	"ГУТАЛ" ХК	33.3%

27	"ШИВЭЭ ОВОО" ХК	86.1%
28	"АЙТҮҮЛС" ХК	84.7%
29	"БУЛИГААР" ХК	84.7%
30	"ГОЛОМТ БАНК" ХК	84.7%
31	"МОНГОЛ БАЗАЛТ" ХК	84.7%
32	<b>"МОНГОЛ ШУУДАН" ХК</b>	<b>84.7%</b>
33	"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН" ХК	84.7%
34	<b>"БАГАНУУР" ХК</b>	<b>83.3%</b>
35	<b>"УВС ХҮНС" ХК</b>	<b>83.3%</b>
36	<b>"Э-ТРАНС ЛОЖИСТИКС" ХК</b>	<b>83.3%</b>
37	"МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО" ХК	81.9%
38	<b>"ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ" ХК</b>	<b>81.9%</b>
39	<b>"ЭМ ЖИ ЭЛ АКУА" ХК</b>	<b>81.9%</b>
40	<b>"ЭРЭЭНЦАВ" ХК</b>	<b>79.2%</b>
41	<b>"МОН НАБ" ХК</b>	<b>77.8%</b>
42	"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК	76.4%
43	<b>"АТАР-ӨРГӨӨ" ХК</b>	<b>75.0%</b>
44	<b>"ЭРЧИМ БАЯН-ӨЛГИЙ" ХК</b>	<b>73.6%</b>
45	"БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ" ХК	68.1%
46	"БИ ДИ СЕК ҮЦК" ХК	68.1%
47	<b>"ХАЙ БИ ОЙЛ" ХК</b>	<b>68.1%</b>
48	"ДАРХАН НЭХИЙ" ХК	65.3%
49	"УЛААНБААТАР ХИВС" ХК	65.3%
50	"УЛААНСАН" ХК	65.3%
51	<b>"ГАЗАР ШИМ ҮЙЛДВЭР" ХК</b>	<b>63.9%</b>
52	"ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС" ХК	63.9%
53	"ХОТ ДЕВЕЛОПМЕНТ" ХК	63.9%
54	"МАХИМПЕКС" ХК	61.1%
55	"МОНИНЖБАР" ХК	61.1%
56	"ТАЛХ ЧИХЭР" ХК	61.1%

83	"ХАРХОРИН" ХК	33.3%
84	"МОГОЙН ГОЛ" ХК	31.9%
85	"БЭРХ УУЛ" ХК	30.6%
86	"ИХ БАРИЛГА" ХК	30.6%
87	"АРИГ ГАЛ" ХК	26.4%
88	"МОНГОЛ ШИЛТГЭЭН" ХК	25.0%
89	"ТАВИЛГА" ХК	23.6%
90	"ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС" ХК	23.6%
91	"ЭРДЭНЭТ УС, ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК	23.6%
92	"ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ХК	22.2%
93	"АРВИЖИХ" ХК	19.4%
94	"БАЯН ТЭЭГ" ХК	16.7%
95	"ДЭВШИЛ МАНДАЛ" ХК	16.7%
96	"МЕРЕКС" ХК	16.7%
97	"АЗЫК" ХК	15.3%
98	"БҮТЭЭЛЧ ҮЙЛС" ХК	15.3%
99	"ДОРНОД ХУДАЛДАА" ХК	15.3%
100	"И ЭС ЖИ ФАЙНАНС" ХК	15.3%
101	"ЖЕНКО ТУР БЮРО" ХК	15.3%
102	"ЛЮКС ЗАНАДУ ГРУПП" ХК	15.3%
103	"МОНГОЛ НЭХМЭЛ" ХК	15.3%
104	"МОНГОЛ САВХИ" ХК	15.3%
105	"НЭХЭЭСГҮЙ ЭДЛЭЛ" ХК	15.3%
106	"ТАВАН ТОЛГОЙ" ХК	15.3%
107	"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК	15.3%
108	"ХИШИГ УУЛ" ХК	15.3%
109	"ХӨВСГӨЛ" ХК	15.3%
110	"ШАРЫН ГОЛ" ХК	15.3%
111	"СИЛИКАТ" ХК	13.9%
112	"СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП" ХК	12.5%

-оО-

